

# Корона вирусын эсрэг вакцин хийлгэсэн бүртгэлгүй оршин сууж буй гадаадын иргэн сайн дураараа нутаг буцах тохиолдолд торгуулиас чөлөөлж, хилээр нэвтрэх хязгаарлалтыг түдгэлзүүлнэ.

## □ Хамаарах хүрээ

◦ БНСУ-д '21.12.31. хүртэл вакцин хийлгэсэн бүртгэлгүй оршин сууж буй гадаадын иргэн\* сайн дураараа тус улсаас гарсан тохиолдолд

\* эрүүгийн гэмт хэрэгтэн, хорио цээрийн дэглэм зөрчсөн этгээд, журамлагдсан болон цагдаагийн алба хаагчид цагаачлалын албанд хүлээлгэн өгсөн гадаадын иргэн хамаарахгүй болно.

## □ Агуулга

### ◦ Урьдчилан сэргийлэх тарилга

- Нэг удаагийн (жишээ нь Янсен) вакцин эсвэл хоёр тунтай вакцин хийлгэж (жишээ нь: Pfizer, Moderna, AstraZeneca гэх мэт) дууссан иргэн\*

\* Хэрэгжүүлж эхлэхээс өмнө ('21.10.12)Вакцины бүрэн тунд хамрагдсан бүртгэлгүй гадаад иргэнд ч хамаарна.

- Вакцины бүрэн тунд хамрагдсанаас **14** хоног өнгөрөөгүй ч сайн дураараа нутаг буцаж буй хүмүүст хөнгөлөлт үзүүлнэ.

\* **Нотлох бичиг:** Вакцинд хамрагдсан гэрчилгээ (Соов цахим гэрчилгээг хэвлэн гаргасан байх эсвэл цаасан гэрчилгээ)

◦ **Хөнгөлөлт:** Сайн дураар нутаг буцах тохиолдолд торгууль төлөхөөс чөлөөлөх, хилээр нэвтрэх хязгаарлалтыг түдгэлзүүлэх

◦ **Хэрэгжүүлэх хугацаа:** '21.10.12. (Мягмар гараг) ~ тусгайлан тогтоох өдөр хүртэл\* (түр хэрэгжүүлэх)

\* Цаашид COVID-19-ийн нөхцөл байдлаас хамаарч дуусах огноог тусад нь зарлана.

## □ Анхаарах зүйл

◦ Одоо хэрэгжиж буй 「Сайн дураараа нутаг буцахаа урьдчилан мэдэгдэх систем」-ийн дагуу

- Цагаачлалын албанд **сайн дураар нутаг буцах тухай** биечлэн **очиж урьдчилан мэдэгдэх эсвэл онлайнаар урьдчилан мэдэгдэх шаардлагатай.**

- **Тухайн өдөр** нисэх онгоцны буудлаар дамжуулан **торгуулиас чөлөөлөгдөх, хил нэвтрэх хязгаарлалтыг түдгэлзүүлэх** хөнгөлөлтөд хамрагдах боломжтой.

※ **Лавлах болон орчуулга :** Гадаадын иргэдийн мэдээллийн төв (1345)

Ажлын цаг	Зөвлөгөө, орчуулгын үйлчилгээ авах боломжтой хэл
24 цаг	Англи, Хятад
09:00~18:00	Япон, Вьетнам, Тайланд, Индонез, Орос, Монгол, Бангладеш, Пакистан, Непал, Камбож, Мьянмар, Франц, Герман, Испани, Филиппин, Араб, Шри-Ланка

<Энэ орчуулгыг Данури төв 1577-1366 хийсэн болно>